



КОМПАНИЙН
ХҮЛЭМЖИЙН ХИЙН
ЯЛГАРУУЛАЛТЫН
ТАЙЛАН
2025

ХАРИУЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ

МИК Холдинг ХК болон түүний охин компаниуд нь бидний оршин буй эх дэлхийд тулгамдаад буй уур амьсгалын өөрчлөлт, нийгмийн тэгш бус байдал болон бизнесийн ёс зүйн асуудлыг шийдвэрлэхэд чухалчлан оролцох, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой хөгжлийн зорилго, зорилтуудыг биелүүлэхэд хувь нэмрээ оруулах, байгаль орчин, нийгэм ба засаглалын зарчмуудыг хариуцлагатайгаар хэрэгжүүлэх зорилгоор “МИК Групп компанийн Тогтвортой хөгжлийн бодлого”-ыг 2024 онд баталсан.

Энэхүү бодлого нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой хөгжлийн зорилгууд (Sustainable Development Goals, SDGs)-ыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах, мөн Байгаль орчин, Нийгэм, Засаглал (Environmental, Social and Governance – ESG)-ын зарчмуудыг үйл ажиллагаандаа хариуцлагатайгаар хэрэгжүүлэх компанийн тууштай зорилтыг илэрхийлж байна.

Мөн 2023 онд МИК Холдинг ХК нь компанийн үнэт зүйлсийнхээ хүрээнд Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулж, байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг багасгах үүрэг хариуцлагыг хүлээн хүлэмжийн хийг сааруулахад хувь нэмрээ оруулах үүднээс Partnership for Carbon Accounting Financials (PCAF) буюу санхүүгийн салбарт хүлэмжийн хийг хэмжих хамтын ажиллагааны санаачлагад нэгдэж, “Хүлэмжийн хийн ялгаруулалтыг стандартын дагуу хэмжиж, ил тод мэдээлэх” үүрэг хүлээсэн билээ.

Энэхүү санаачилгын хүрээнд компани нь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагааг дэмжих, Улаанбаатар хотын агаарын чанарыг сайжруулахад хувь нэмэр оруулах, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахыг зорин ажиллаж байна.

“Хүлэмжийн хийн протокол” (Greenhouse Gas protocol)-ын дагуу Хамрах хүрээ 3-т хамаарах МИК Холдинг ХК болон түүний охин компаниудын бизнесийн үйл ажиллагааны хүрээнд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт, худалдан авсан ипотекийн зээлийн багц дах шууд бусаар ялгаруулж буй хүлэмжийн хийг тооцох аргачлалыг PCAF-ын “Олон улсын хүлэмжийн хийн тайлагналын стандарт”-ын дагуу боловсруулж, тооцсон. 2025 оны байдлаар компанийн бизнесийн үйл ажиллагаагаар санхүүжүүлсэн харилцагч талууд хүлэмжийн хийн ялгарлын тайлагналыг хараахан тайлагнаагүй, Монгол Улсад эдийн засгийн салбар бүрийн хүлэмжийн хийн ялгарлын дата мэдээлэл, чанартай өгөгдлийн хүртээмж хязгаарлагдмал зэргээс үндэслэн бид хүлэмжийн хийн ялгарлыг PCAF-ын санал болгосон CEDA (Comprehensive Environmental Data Archive) болон Монгол улсын нийтэд нээлттэй албан ёсны эх сурвалжуудын мэдээлэлд үндэслэн тооцоолон үнэлсэн болно.

МИК ООСК ХХК нь хүлэмжийн хийн ялгарлаа World Resources Institute (WRI) болон World Business Council for Sustainable Development (WBCSD) байгууллагуудын хамтран боловсруулсан Greenhouse Gas Protocol – Corporate Accounting and Reporting Standard, мөн ISO 14064-1:2018 "Specification with guidance at the organization level for quantification and reporting of greenhouse gas emissions and removals" стандартын шаардлагын дагуу тооцсон.

Энэхүү тайлагнал нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлал, баримт бичгүүдийг үндэслэн компани өөрийн сонгон ашигласан арга зүйгээр бэлтгэгдсэн болно. Тооцоололд ашигласан мэдээлэл, итгэлцүүрүүд нь олон нийтэд нээлттэй эх сурвалжууд, Монгол Улсын албан ёсны мэдээлэлд боломжит түвшинд тулгуурласан бөгөөд мэдээлэл хангалтгүй эсвэл тодорхой бус нөхцөлд PCAF-ын санал болгосон дата өгөгдлийг ашигласан. Энэхүү тайлангийн үзүүлэлтээс үүсэж болзошгүй аливаа үр дагаварт компани хариуцлага хүлээхгүй бөгөөд тайлангийн үр дүнг зөвхөн мэдээллийн зорилгоор ашиглахыг зөвлөж байна.

Энэхүү тайлагналын зарим мэдээлэл нь Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо ISO 27001:2022 стандартын дагуу боловсруулагдсан болно.

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

МИК Холдинг ХК (цаашид “Компани” гэх) нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу 2008 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр үүсгэн байгуулагдаж, идэвхтэй үйл ажиллагааг 2015 оны 12 дугаар сарын 14-ний өдөр өөрийн охин компаниудын хамт (цаашид “Групп” гэх) холдинг компанийн хэлбэрээр явуулж байна. МИК Групп компани нь Монгол Улсад ипотекийн хоёрдогч зах зээлийг хөгжүүлэхийг зорьж, МИК Холдинг ХК, түүний охин компани МИК ОССК ХХК, тэдгээрийн охин компаниуд болох МИК Актив Тусгай Зориулалтын Компани (ТЗК)-ууд, МИК Рийл Эстэйт ХХК болон Протегио Ферст ХХК-аас бүрдэн, үйл ажиллагаагаа явуулж байна.

МИК Холдинг ХК нь Монголын Хөрөнгийн Бирж (MSE: MIK) дээр бүртгэлтэй хувьцаат компани бөгөөд 2015 онд МИК ОССК ХХК-ийн хувьцаа эзэмшигчид Хувьцаа солилцох болон эрх шилжүүлэх гэрээний дагуу МИК Холдинг ХК-д зохих хувьцааг шилжүүлэн, МИК Холдинг ХК-ийг толгой компани болгон өөрчлөн байгуулсан. Түүний хүрээнд МИК ОССК ХХК-ийн хувьцааг эзэмшин, удирдлагаар ханган ажиллаж байна.

МИК ОССК ХХК нь Орон Сууцны Санхүүжилтийн Компани бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооноос авсан тусгай зөвшөөрлийн хүрээнд Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, Хөрөнгө итгэмжлэн удирдах болон Хэлцэл эрхлэн гүйцэтгэх үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа явуулж байна.

МИК ОССК ХХК нь дараах хоёр үндсэн бизнесийн загвараар үйл ажиллагаа явуулдаг.

- 1. Үнэт цаасжуулах үйл ажиллагааны загвар:** Засгийн газраас хэрэгжүүлж буй хөнгөлөлттэй хүүтэй орон сууцны зээлийн үйл ажиллагааны дагуу олгосон ипотекийн зээлийг буцаах нөхцөлгүйгээр багцлан худалдан авч, ТЗК-аар дамжуулан ипотекийн зээлээр баталгаажсан бондыг гаргах үйл ажиллагаа юм. Ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас тогтмол хүүтэй бөгөөд үнэт цаас нь Давуу эрхтэй (арилжсан бондын үнийн дүнгийн 90%) болон энгийн (арилжсан бондын үнийн дүнгийн 10%) бондоос бүрддэг.
- 2. Хөрвөх чадвар бий болгох загвар:** Компани нь арилжааны банкууд, банк бус санхүүгийн байгууллагаас зах зээлийн хүүтэй иргэдийн орон сууцны зээл болон автомашины зээлийг буцаах нөхцөлтэйгөөр худалдан авч, компанийн баланс дээр шилжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Энэхүү үйл ажиллагааг өөрийн эх үүсвэр болон дотоод, гадаадын хөрөнгийн зах зээлээс татан төвлөрүүлсэн эх үүсвэрээр санхүүжүүлдэг бөгөөд арилжааны банкнууд, банк бус санхүүгийн байгууллагуудын хөрвөх чадварыг сайжруулах, шинээр ипотекийн зээлийн эх үүсвэрийг бий болгоход ач холбогдолтой юм.

Орон сууцжуулах үйл ажиллагаа нь 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн чухал хэсэг бөгөөд Тогтвортой хөгжлийн олон зорилтуудыг хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулдаг. Иргэдийн орон сууцны нөхцөлийг сайжруулах нь эрүүл мэнд, боловсрол, эдийн засгийн боломжийг нэмэгдүүлэхээс гадна өрхийн амьжиргааг дээшлүүлэх, ядуурлыг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Үүний зэрэгцээ нийгмийн тэгш бус байдлыг бууруулж, байгалийн гамшиг болон эдийн засгийн хүндрэлд олон нийтийн дасан зохицох, даван туулах чадавхыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулдаг билээ.

МИК нь арилжааны банкуудаас олгосон ипотекийн зээлийг худалдан авч үнэт цаасжуулах замаар Монгол Улсын орон сууц санхүүжилтийн тогтолцоонд чухал үүрэг гүйцэтгэн ажиллаж байна. 2013 оноос хэрэгжүүлж буй төрөөс дэмжлэгтэй ипотекийн зээлийн хөтөлбөр нь иргэдийн ипотекийн зээлийн хүртээмжийг тасралтгүй хангахаас гадна банк, санхүүгийн салбарын хөрвөх чадварыг нэмэгдүүлж байна. Түүнчлэн энэхүү тогтолцоо нь ажлын байр шинээр бий болгох, барилга, үл хөдлөх хөрөнгө болон барилгын материалын салбарын эрэлт, эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх замаар улсын эдийн засгийн өсөлтийг дэмждэг. МИК Группийн үйл ажиллагаа нь хот төлөвлөлтийг сайжруулах, ядуурал болон нийгмийн тэгш бус байдлыг бууруулах, нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг дэмжих, улмаар шударга, тогтвортой орон сууцны зах зээлийг төлөвшүүлэхэд эерэг системийн нөлөө үзүүлдэг.

МИК Групп нь байгаль орчны өмнө тулгамдаж буй сорилтуудыг шийдвэрлэхийн зэрэгцээ нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжих нь байгууллагын тэргүүлэх зорилтын нэг гэж үздэг. Иймээс тогтвортой хөгжлийн зарчмыг компанийн үнэт зүйлсийн үндэс болгон бүх үйл ажиллагаа, бизнесийн шийдвэр, засаглалын тогтолцоондоо тууштай хэрэгжүүлэхийг зорин ажиллаж байна.

КОМПАНИЙН САНХҮҮЖҮҮЛСЭН ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ

Тайлагналын хугацаа: 2025 оны 1 дүгээр сарын 1-нээс 2025 оны 12 дугаар сарын 31

Тайлагналд хамрагдах хөрөнгө: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх биржид бүртгэлтэй болон бүртгэлгүй хувьцаа, компанийн бонд, бизнесийн санхүүжилт ба төслийн санхүүжилт, ипотекийн зээл болон автомашины зээл.

Тооцоо бүртгэл, тайлагналын аргачлал:

Санхүүжүүлсэн хөрөнгийн хүлэмжийн хийн ялгарлыг "PCAF Financed Emissions Standard" болон "GHG Protocol"-ын шаардлагад нийцүүлэн тайлагнасан болно.

Хөрөнгийн ангилал ба хамрах хүрээ:

МИК Холдинг ХК болон түүний охин компаниудын санхүүжүүлсэн хөрөнгүүд нь дараах байдлаар энэхүү хүлэмжийн хийн ялгарлын тооцоололд хамрагдсан.

Хөрөнгийн ангилал	Санхүүжүүлсэн ХХЯ тооцоонд хамрагдсан хувь (үлдэгдэл дүнгээр)
Биржид бүртгэлтэй хувьцаа	100%
Биржид бүртгэлгүй хувьцаа*	95%
Компанийн бонд	100%
Бизнесийн санхүүжилт	100%
Төслийн санхүүжилт	100%
Ипотекийн зээл	100%
Автомашины зээл	100%

*Хөрөнгийн биржид бүртгэлгүй хувьцаа нь холбоотой талуудад оруулсан хөрөнгө оруулалтаас бүрдэх бөгөөд хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийг "0"-ээр тооцсон.

Суурь жилийн дахин тооцооллын аргачлал:

МИК Холдинг ХК нь санхүүжүүлсэн хөрөнгийн хүлэмжийн хийн ялгарлын хэмжилтийн нийцтэй байдал, харьцуулах боломж, үнэн зөв байдлыг хангахыг эрмэлзэж ажилладаг. Иймд томоохон өөрчлөлтүүд гарсан тохиолдолд тэдгээрийг тусган суурь жилийн ялгарлын тооцоо, хэмжилтийг дахин тооцоолж шинэчлэх шаардлагатай гэж үздэг.

Суурь жилийн сонголт ба Хэмжилт:

Дэлхийн хүлэмжийн хийн тооцоолол, тайлагналын стандарт болох "GHG Protocol"-ын дагуу МИК Холдинг ХК болон түүний охин компаниуд нь 2024 оныг суурь жилээр тодорхойлон, санхүүжүүлсэн хөрөнгийн нүүрстөрөгчийн ялгарлыг анх удаа тооцож, тайлагнасан. Бид "GHG Protocol"-ын дагуу тогтмол суурь жилийн зарчмыг мөрдлөг болгож онцгой нөхцөл үүсч, аргачлалд өөрчлөлт оруулах тохиолдолд суурь жилийн тооцооллыг дахин хянаж, шинэчилнэ.

Дахин тооцоолол хийх нөхцөл ба Ач холбогдлын босго:

МИК Холдинг ХК нь санхүүжүүлсэн хөрөнгийн хүлэмжийн хийн ялгарлын суурь жилийн мэдээллийг тогтмол хянаж, Хамрах хүрээ 1 болон Хамрах хүрээ 2 ялгарлаар тооцсон нүүрстөрөгчийн ялгарал өмнөх тооцооллоос ± 10 хувь буюу түүнээс дээш хэмжээгээр (тонн CO_2 экв/мян.төг-өөр илэрхийлэгдсэн) өөрчлөгдсөн тохиолдолд дахин тооцоолно. Мөн Хамрах хүрээ 3 ялгарлын өгөгдлийн хүртээмж, нарийвчлал тасралтгүй өөрчлөгдөж байдаг тул тогтмол босго үзүүлэлт хэрэглэхгүйгээр тухайн нөхцөл байдалд үндэслэн үнэлгээ хийнэ.

Суурь жилийн мэдээллийг дахин тооцоолох шаардлагатай нөхцөлүүдэд:

- Аргачлалын өөрчлөлт:** МИК Холдинг ХК болон түүний охин компаниудын нүүрстөрөгчийн шууд бус ялгарлыг тооцоолох аргачлалд томоохон өөрчлөлт орох, эсвэл үндсэн өгөгдөл ба тооцооллын аргачлалд ихээхэн нөлөө үзүүлэх өөрчлөлт гарах тохиолдол;
- Өгөгдлийн эх сурвалжийн өөрчлөлт:** Тайлант хугацаануудын хооронд өгөгдлийн харьцуулалт, нийцэлд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхүйц байдлаар үндсэн өгөгдлийн эх сурвалж эсвэл өгөгдөл нийлүүлэгч өөрчлөгдсөн тохиолдол;
- Өгөгдлийн чанарын сайжруулалт болон алдааны залруулга:** Суурь жилийн ХХЯ тооцоололд материаллаг нөлөө үзүүлэхүйц алдаа, өгөгдөл болон аргачлалын сайжруулалт, эсхүл хуримтлагдсан нарийвчлалын зөрүүг тогтоосон тохиолдол.

Дахин тооцоолол хийх хугацаа:

Хамрах хүрээ 3-ын хөрөнгө оруулалттай холбоотой шууд бус ялгарлын хүрээнд илүү нарийвчилсан өгөгдөл ашиглах боломж бүрдсэнтэй холбоотой ипотекийн зээлийн багц болон автомашины зээлийн багцын суурь жилийн ялгарлын тооцооллыг дахин шинэчилсэн. Үүний үр дүнд суурь жилийн болон тайлант жилийн ялгарлын дүнгийн хоорондох өөрчлөлт багассан.

ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРУУЛАЛТЫН ТАЙЛАН

Компанийн нийт хүлэмжийн хийн ялгаруулалт, 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар:

Тогтвортой хөгжил болон байгаль орчныг хамгаалах асуудал нь дэлхий нийтийн тэргүүлэх зорилтуудын нэг болж, нүүрстөрөгчийн ялгарлыг хэмжих, бууруулах нь бүх салбарын байгууллагуудын хүлээх ёстой чухал хариуцлага болоод байна. Иймээс бидний зорилт нь эхлээд одоогийн хүлэмжийн хийн ялгарлын түвшингээ иж бүрэн үнэлж тодорхойлох, улмаар хэмжиж болохуйц зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэж байна. МИК Холдинг ХК болон түүний охин компаниуд үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг өөрийн үйл ажиллагаанаас ялгаруулж буй хүлэмжийн хий (Хамрах хүрээ 1 болон 2), мөн шууд бусаар компанийн бизнесийн үйл ажиллагаанаас ялгаруулж буй хүлэмжийн хий (Хамрах хүрээ 3)-г ил тод тайлагнадаг.

ХАМРАХ ХҮРЭЭ	ХАМРАХ ХҮРЭЭНИЙ ТАЙЛБАР	ХХЯ-ын ТӨРӨЛ	ХХЯ (тонн со2 экв/жил)
ХАМРАХ ХҮРЭЭ 1 (Нийлүүлэлтийн өмнөх)	Компанийн өмчилж байгаа болон хяналтад байдаг тээврийн хэрэгсэл, агааржуулагч, эрчим хүчний үүсгүүр зэргээс үүдэлтэй шууд ялгаруулж буй хүлэмжийн хий хамаарна.	Суурин шаталт	0.18
		Хөдөлгөөнт шаталт	16.79
ХАМРАХ ХҮРЭЭ 2 (Нийлүүлэлтийн өмнөх)	Компанийн өөрийн оффисын ашиглалтын хүрээнд хэрэглэж буй цахилгаан эрчим хүч, төвлөрсөн дулаан хангамжийн хэрэглээтэй холбоотой шууд бус эрчим хүчний ялгаруулалт хамаарна.	Цахилгаан	129.27
		Дулаан/ Хөргөлт	185.97
ХАМРАХ ХҮРЭЭ 3 (Нийлүүлэлтийн өмнөх болон дараах)	Компанийн өдөр тутмын үйл ажиллагаа болон өөрийн эзэмшдэггүй эсвэл хянадаггүй эх үүсвэрээс үүссэн бусад бүх шууд бус хүлэмжийн хийн ялгаруулалт хамаарна. Үүнд, бүтээгдэхүүн ашиглах, бизнес аялал, тээвэрлэлт, түгээлт гм Мөн МИК Групп компанийн бизнесийн үйл ажиллагааны хүрээнд худалдан авсан зээлийн багц, санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын багцын харилцагч талаас хамаарах хүлэмжийн хийн ялгаруулалт багтана.	Албан томилолт	23.1
		Хог хаягдал	0.745
		Ус хангамж	0.386
		Санхүүжүүлсэн хөрөнгийн ХХЯ (Мэдээллийн чаанар 4)	514,505.81
Нийт хүлэмжийн хийн ялгаруулалт			514,862.25

Тайлант болон суурь жилийн хугацааны Компанийн нийт ХХЯ-ын өөрчлөлт :

Компанийн тээврийн хэрэгслийн ашиглалтын хүрээнд бензин хөдөлгүүртэй 3 автомашиныг ашиглалтаас гаргаж “Хамрах хүрээ 1”-н ялгаруулалтыг 15.3%-иар бууруулсан. Энэхүү шийдвэрийн үр дүнд түлшний хэрэглээ мэдэгдэхүйц буурч, түүнтэй холбоотой ХХЯ болон зардал багассан. Цахилгаан эрчим хүч болон дулааны хэрэглээнээс үүсэх “Хамрах хүрээ 2”-н ялгаруулалт 9.3 тонноор буурч, 2.9%-ийн бууралтыг үзүүлсэн. Мөн эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээг дэмжиж, хариуцлагатай менежментийг хэрэгжүүлснээр барилга байгууламжийн ашиглалт болон эрчим хүчтэй холбоотой зардлыг тогтвортой түвшинд хадгалж чадсан. Санхүүжүүлсэн хөрөнгөтэй холбоотой “Хамрах хүрээ 3”-н ялгаруулалт мөн 15.3%-иар буурсан. Энэхүү бууралтад бүртгэлтэй хувьцаа, бондын хөрөнгө оруулалтын үлдэгдэл буурсан, мөн өмнөх онтой харьцуулахад автомашины зээлийн багцын үлдэгдэл буурсан нь голлон нөлөөлсөн байна.

ТӨРЛҮҮД	Суурь жилийн ХХЯ 2024 (тонн со2 экв/жил)	Тайлант жилийн ХХЯ-2025 (тонн со2 экв/жил)	Өөрчлөгдсөн хувь, %
Хамрах хүрээ 1 нийт ХХЯ	20.04	16.97	-15.32%
Хамрах хүрээ 2 нийт ХХЯ	324.53	315.24	-2.86%
Хамрах хүрээ 3 нийт ХХЯ	607,528.51*	514,530.04	-15.31%
Нийт ХХЯ	607,873.08	514,862.25	-15.30%

*Суурь оны санхүүжүүлсэн хөрөнгийн ялгарлын хувьд мэдээллийн чанар сайжирч, нарийвчилсан өгөгдөл ашиглах боломж бүрдсэнтэй холбоотой ипотекийн зээл, автомашины зээлийн хүлэмжийн хийн ялгарлыг дахин тооцоолсон. Эдгээр өөрчлөлтийн үр дүнд суурь жилийн болон тайлант жилийн ялгарлын үзүүлэлтүүдийн хооронд мэдэгдэхүйц зөрүү гарсан болно.

ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРУУЛАЛТЫН ТАЙЛАН

Санхүүжүүлсэн хөрөнгийн хүлэмжийн хийн ялгарал, хөрөнгийн төрлөөр:

Биржид бүртгэлтэй болон бүртгэлгүй хувьцаа, бонд, төслийн санхүүжилттэй холбоотой ялгарлыг РСАФ-ийн удирдамжийн дагуу эдийн засгийн үйл ажиллагаанд суурилсан аргачлалыг ашиглан тооцоолсон. Эдгээр хөрөнгийн ангилалд ашигласан үндсэн өгөгдлийн мэдээллийн чанарын дундаж үнэлгээ 4 байна.

Автомашины зээлийн санхүүжилттэй холбоотой ялгарлыг (голчлон суудлын автомашины зээлийн хувьд) тээврийн хэрэгслийн хуваарилалтын аргачлал ашиглан тооцоолсон бөгөөд мэдээллийн чанарын үнэлгээ 3 байна. ХХЯ-ыг тухайн автомашины үйлдвэрлэсэн он болон загварын талаарх боломжит мэдээлэлд үндэслэн автомашины ашиглалтын үзүүлэлт болох туулсан зам, түлшний хэрэглээ, түлшний төрөл тус бүрд харгалзах ялгарлын коэффициентийг ашиглан ялгарлыг тооцсон.

Ипотекийн зээлийн санхүүжилттэй холбоотой ялгарлыг биет үйл ажиллагаанд суурилсан аргачлал ашиглан тооцоолсон. Энэхүү хөрөнгийн ангилалд ашигласан мэдээллийн чанарын үнэлгээ 4 байна.

Үйл ажиллагаа (Хөрөнгийн ангиллаар)	Хамрах хүрээ 1 (тонн со2 экв/жил)	Хамрах хүрээ 2 (тонн со2 экв/жил)	Хамрах хүрээ 3 (тонн со2 экв/жил)	Нийт ХХЯ (тонн со2 экв/жил)	Ялгарлын эрчимжилт (тонн со2 экв/мян.төг)	Мэдээллийн чанар
1. ХБ-д бүртгэлтэй хувьцаа, бонд	137,534.36	14,292.71	22,725.43	174,552.50	0.00	4
Бүртгэлтэй Хувьцаа	1.16	0.16	1.42	2.74	0.00	4
Бүртгэлгүй Хувьцаа	0.13	0.14	0.93	1.20	0.00	4
Бонд	31,125.97	3,316.78	5,655.61	40,098.36	0.00	4
Бизнесийн санхүүжилт	106,402.97	10,975.27	17,040.23	134,418.47	0.00	4
Төслийн санхүүжилт	4.14	0.36	27.24	31.74	0.00	4
2. Ипотекийн зээл	-	-	-	305,062.64	0.00	4
3. Автомашины зээл	-	-	-	34,890.67	0.02	3
НИЙТ	137,534.36	14,292.71	22,725.43	514,505.81	0.02	4